



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/241

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар хуралдааны 10 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.11 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулж буй залуучуудын байгууллагын үйл ажиллагаанд ахмад зөвлөхүүдийн санал бодлыг тусгах, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, мэргэжил сонголтын талаар санал солилцох үйл ажиллагааны зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.


3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

201010931



Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дүгээр сарын 02 өдрийн
Арчи дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Ахмад, залуучуудын санал солилцох үйл ажиллагааны зардал	80	62,500	5,000,000
	Дүн			5,000,000